АККУРЭЙТ ФИНАНС-АУДИТ ХХК

“ЭЛ ЭС ФИНАНС ББСБ” ХХК

Аудитлагдсан санхүүгийн тайлан
2022 оны 12 дугаар сарын 31

АГУУЛГА	ХУУДАС
ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН	3
ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН	4
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН	5
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН	5
ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	6-7
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД	8-10
МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ	11
АУДИТОРЫН ЗӨВЛӨМЖ	12

АККУРЭЙТ ФИНАНС АУДИТ
Монгол улс, Улаанбаатар хот
Баянгол дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө,
4 дүгээр хороо, Тэнүүн апартмент 3-205 тоот
Утас: 70133743, 99995143, Факс: (976) 7013-3743
E-mail: acc.fin.audit@gmail.com
accuratefinance_audit@yahoo.com

2023 03.27 № АА-13
танай_____-ны №_____-т

Аудит, нягтлан бодох бүртгэл,
санхүүгийн зөвлөгөөний
итгэмжлэгдсэн байгууллага

"Эл Эс Финанс ББСБ" ХХК-ийн
Захирал Б.Болд танаа

ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Бид "Эл Эс Финанс ББСБ" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тодруулга болон бусад тайлангуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар "Эл Эс Финанс ББСБ" ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд нь бүхий л материалаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудиторын үүрэг хариуцлага нь хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах юм.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх, түүвэр шалгалтын арга ашиглан магадлах ажил багтана.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц материаллаг алдаа илрээгүй.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв толилуулах нь Удирдлагын үүрэг хариуцлага байдаг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцооллуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх үүрэг хариуцлагатай байна.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго нь санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв бөгөөд шударгаар толилуулагдсан эсэхийг үндэслэлтэй баталгаажуулж аудиторын дүгнэлтэнд тусгах явдал юм.

Бидний олж авсан үндэслэлтэй нотолгоо нь энэхүү гаргасан дүгнэлтэнд баталгаатай үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байгаа ч Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байж болзошгүй залилан эсвэл алдааг бүрэн илэрхийлнэ гэсэн баталгаа биш юм.

ЗАХИРАЛ Ж.ОЮУНБИЛЭГ

(төгрөгөөр)

БАЛАНСЫН ЗҮЙЛ	Тод	2021/12/31	2022/12/31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3	259,526,292.43	528,800,659.69
Зээл (цэврээр)	4	1,652,437,709.75	1,355,444,065.75
Бусад авлага	5	528,909,960.00	650,416,243.00
Бараа материал		-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн		**2,440,873,962.18**	**2,534,660,968.44**
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	6	58,393,359.03	68,460,377.02
Хуримтлагдсан элэгдэл	6	(21,848,460.40)	(30,953,516.61)
Биет бус хөрөнгө	6	2,182,342.21	1,848,216.84
Хуримтлагдсан элэгдэл		-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		**38,727,240.84**	**39,355,077.25**
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		**2,479,601,203.02**	**2,574,016,045.69**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн өглөг		-	-
Цалингийн өглөг	7	371,800.00	314,500.00
Татвар, нийгмийн даатгалын өглөг	7	32,095,479.48	32,347,259.81
Бусад өглөг	7	43,775,860.10	47,632,860.10
Богино хугацаат өр төлбөрийн дүн		**76,243,139.58**	**80,294,619.91**
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл		-	-
Бусад урт хугацаат өр төлбөр		-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-	-
Өр төлбөрийн нийт дүн		**76,243,139.58**	**80,294,619.91**
Эздийн өмч			
Энгийн хувьцаа	8	1,900,000,000.00	1,900,000,000.00
Давуу эрхтэй хувьцаа		-	-
Хувьцаат капиталын дүн			
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	8	503,358,063.44	593,721,425.78
Тайлант үеийн		162,512,764.07	72,617,062.21
Өмнөх үеийн		340,845,299.37	521,104,363.57
Эздийн өмчийн дүн		**2,403,358,063.44**	**2,493,721,425.78**
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		**2,479,601,203.02**	**2,574,016,045.69**

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Тод	2021/12/31	2022/12/31
1 Хүүгийн орлого	9	538,007,538.00	430,224,745.00
2 Хүүгийн зардал		-	-
Цэвэр хүүгийн орлого		**538,007,538.00**	**430,224,745.00**
3 Хүүгийн бус орлого	9	6,777,482.12	1,099,750.00
4 Хүүгийн бус зардал	10	(328,741,508.45)	(362,220,117.30)
Цэвэр хүүгийн бус орлого		**(321,964,026.33)**	**(361,120,367.30)**
5 Болзошгүй эрсдлийн сан байгуулахаас өмнөх үйл ажиллагааны ашиг/алдагдал/		216,043,511.67	69,104,377.70
6 Болзошгүй эрсдлийн зардал	10	(41,783,780.00)	-
Үндсэн үйл ажиллагааны ашиг/алдагдал/		**174,259,731.67**	**69,104,377.70**
7 Үндсэн бус үйл ажиллагааны орлого	9	7,138,375.00	30,500,267.00
8 Үндсэн бус үйл ажиллагааны зардал	10	(1,461,500.00)	(3,822,850.00)
Ердийн үйл ажиллагааны ашиг/алдагдал/		**179,936,606.67**	**95,781,794.70**
9 Ердийн бус орлого		-	-
10 Ердийн бус зардал		-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал/		**179,936,606.67**	**95,781,794.70**
Орлогын татварын зардал	11	(17,423,841.90)	(23,164,732.49)
Цэвэр ашиг		**162,512,764.77**	**72,617,062.21**

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

"Эл Эс Финанс ББСБ" ХХК
Аудитлагдсан өмчийн өөрчлөлтийн тайлан
2022 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хуримтлагдсан ашиг, алдагдал	Нийт дүн
2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**1,900,000,000.00**	**340,845,299.37**	**2,240,845,299.37**
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз/гарз/	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг/(алдагдал)	-	162,512,764.07	162,512,764.07
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**1,900,000,000.00**	**503,358,063.44**	**2,403,358,063.44**
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй цэвэр олз/гарз/	-	17,746,300.13	17,746,300.13
Тайлант үеийн цэвэр ашиг/(алдагдал)	-	72,617,062.21	72,617,062.21
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	**1,900,000,000.00**	**593,721,425.78**	**2,493,721,425.78**

"Эл Эс Финанс ББСБ" ХХК
Аудитлагдсан мөнгөн гүйлгээний тайлан
2022 оны 12 сарын 31

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31	2022/12/31
1.Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	2,259,530,912.98	1,790,028,433.00
2. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зардал	(2,342,964,501.74)	(1,516,931,215.74)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	**(83,433,588.76)**	**273,097,217.26**
3. Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн орлого	-	-
4. Үндсэн бус үйл ажиллагааны мөнгөн зардал	(1,461,500.00)	(3,822,8500.00)
Үндсэн бус үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,461,500.00)	(3,822,850.00)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(84,894,986.18)	269,274,367.26
5. Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	344,421,278.61	259,526,292.43
6. Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	259,526,292.43	528,800,659.69

Нэмэлт тодотголууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ТОДОТГОЛ 1 - ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Компанийн үүсэл гарал

"Эл Эс Финанс ББСБ"® ХХК нь регистрийн 3747468, улсын бүртгэлийн 9015004009 тоот дугаартай 1,900,000.0 мянган төгрөгийн өөрийн хөрөнгөтэй 1 гишүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. "Эл Эс Финанс ББСБ" ХХК нь 2014 онд байгуулагдан "Зээлийн үйл ажиллагаа" чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

2. Байгууллагын бүтэц, зохион байгуулалт

"Эл Эс Финанс ББСБ" ХХК нь ерөнхий захирал, нягтлан бодогч болон дунджаар 7 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

"Эл Эс Финанс ББСБ" ХХК нь 2014 онд Монгол улсын татварын албанд бүртгэгдсэн.
"Эл Эс Финанс ББСБ" ХХК -ийн албан ёсны хаяг: Улаанбаатар хот, СБД, Олимпийн гудамж, 1-р хороо, 8/4-9 тоот

Утас,факс: 7011-6067, 88886067 *Е мэйл хаяг:*

ТОДОТГОЛ 2-НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО

а. Санхүүгийн тайлагналын суурь

"Эл Эс Финанс ББСБ" ХХК-ийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу түүхэн өртгийн зарчмаар аккруэль сууриар бэлтгэгдсэн байна.

"Эл Эс Финанс ББСБ" ХХК нь нягтлан бодох бүртгэлээ Монгол төгрөгөөр бүртгэдэг ба гадаад валютаар гарсан ажил гүйлгээг зөвшөөрөгдсөн аргаар төгрөгт шилжүүлж бүртгэдэг. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа бодлого, зарчим нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад хууль, тогтоомж аргачлал зааврын дагуу явагдаж байна.

б. Санхүүгийн тайланг бэлтгэсэн байдал

"Эл Эс Финанс ББСБ" ХХК нь нягтлан бодох бүртгэлээ санхүүгийн програм дээр хөтлөж байгаа болно.

Санхүүгийн тайлан нь Санхүү байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан гэсэн үндсэн 4 тайлан, нягтлан бодох бүртгэлийн бодлого ба нэмэлт тодруулгаас бүрдсэн байна.

в. Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

"Эл Эс Финанс ББСБ" ХХК нь үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөлд үндэслэн, тасралтгүй үйл ажиллагааны зарчмаар санхүүгийн тайлангаа бэлтгэдэг. Тус байгууллагыг татан буулгах, үйл ажиллагааг зогсоох бодит сонголт байгаагаас бусад тохиолдолд хэрэгжинэ.

г. Санхүүгийн хэрэгслүүд

Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөр нь балансад мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, дансны авлага, өглөг, зээлээс бүрдэнэ.

д. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Компанийн хувьд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь бэлэн мөнгө болон банкин дахь төгрөг, валютаас бүрддэг. Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгадаг.

е. Авлага

Авлагыг үүссэн нэрлэсэн үнээр бүртгэдэг. Авлагадаа найдваргүй авлагын нөөц сан байгуулаагүй.

ё. Бараа материал

Бараа материалын бүртгэлээ "БМ-ын байнгын систем"-ээр хөтөлдөг ба бараа материалын өртөг, зардлыг татварын хуулийн дагуу "Эхэлж авсанаа эхэлж зарлагадах арга"-аар тооцдог.

ж. Үндсэн хөрөнгө

Өртөг. *Үндсэн хөрөнгө нь хуримтлагдсан элэгдэл хассан цэвэр дүнгээр тайлагнагдсан. Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, тухайн хөрөнгийг зориулалтын байршил, нөхцөлд ашиглалтанд оруулахтай холбогдсон бусад зардлаас бүрдэнэ.*

Элэгдэл. *Үндсэн хөрөнгийн элэгдлийг ашиглагдах хугацааны туршид шулуун шугамын аргаар элэгдүүлдэг.*

з. Орлого

Орлого нь хүлээн авсан, эсвэл авахаар хүлээгдэж буй бодит үнэ цэнээр хэмжигдэнэ.

и. Өртөг, зардал

Нийт үйл ажиллагааны зардал нь үйл ажиллагааны /борлуулалтын болон удирдлагын/ зардал, үйл ажиллагааны бус зардал гэсэн 2 категориос бүрддэг.
Үйл ажиллагааны зардал нь ажиллагсадын цалин, нийгмийн даатгалын зардал, бичиг хэрэг, шуудан холбоо, төслийн зардал, түлш шатахуун, үндсэн хөрөнгийн элэгдэл, ашиглалтын болон засвар үйлчилгээний зардал, бусад зардлуудаас бүрдэнэ.
Үйл ажиллагааны бус зардал нь валютын ханшийн өөрчлөлтийн алдагдал, хүү торгуулийн зардлаас бүрдэнэ.

й. Татвар

Ажиллагсадаас авах Хувь Хүний Орлогын Албан Татварыг хуульд заасны дагуу сар бүр суутган авч, татварын байгууллагатайгаа тооцоо хийдэг. Мөн бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд ногдох бусад татварыг суутган тооцоо хийдэг.

к. Нийгмийн даатгалын шимтгэл

Байгууллага нь хуулийн дагуу эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн дагуу суутган авч төсөвт төлдөг.

ТОДОТГОЛ 3 - МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

2021 он болон 2022 оны эцэст тус компанийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл дараах байдалтай байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31	2022/12/31
Касс дахь мөнгө	257,277,320.65	521,796,997.65
Банкин дахь мөнгө	2,248,971.78	7,003,662.04
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	**259,526,292.43**	**528,800,659.69**

ТОДОТГОЛ 4 – ЗЭЭЛ /ЦЭВРЭЭР/

2022 оны эцэст тус компанийн зээлийн үлдэгдэл дараах байдалтай байна

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31	2022/12/31
Зээл	1,722,344,413.00	1,425,350,769.00
Зээлийн эрсдлийн сан	(69,906,703.25)	(69,906,703.25)
Дансны авлагын дүн	**1,652,437,709.75**	**1,355,444,065.75**

ТОДОТГОЛ 5 - БУСАД АВЛАГА

2022 оны эцэст тус компанийн бусад авлагын үлдэгдэл дараах байдалтай байна.

Бусад богино хугацаат авлага

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31	2022/12/31
Авлага	268,700,918.00	458,554,556.00
Хуримтлуулж тооцсон зээлийн хүүгийн авлага	260,209,042.00	191,861,687.00
Дансны авлагын дүн	**528,909,960.00**	**650,416,243.00**

ТОДОТГОЛ 6 - ҮНДСЭН ХӨРӨНГӨ

а. 2022 оны үндсэн хөрөнгийн хөдөлгөөн дараах байдалтай байна.

ҮЗҮҮЛЭЛТ	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Оны эцэст
Тавилга эд хогшил	32,454,687.03	-	32,882.01	32,421,805.02
Компьютер, дагалдах хэрэгсэл	25,938,672.00	10,099,900.00	-	36,038,572.00
Биет бус хөрөнгө	2,182,342.21	-	334,125.37	1,848,216.84
Нийт хөрөнгийн дүн	**60,575,701.24**	**10,099,900.00**	**367,007.38**	**70,308,593.86**
Нийт цэвэр хөрөнгийн дүн	**38,727,240.84**	**-**	**-**	**39,355,077.25**

б. 2022 онд үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэлд гарсан өөрчлөлт дараах байдалтай байна.

ҮЗҮҮЛЭЛТ	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Оны эцэст
Тавилга эд хогшил	9,534,072.48	3,201,343.46	-	12,735,415.94
Компьютер, дагалдах хэрэгсэл	12,314,387.92	5,903,712.75	-	18,218,100.67
Биет бус хөрөнгө	-	-	-	-
Хуримтлагдсан элэгдлийн дүн	**21,848,460.40**	**9,105,056.21**	**-**	**30,953,516.61**

ТОДОТГОЛ 7 - ӨР ТӨЛБӨР

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31	2022/12/31
Цалингийн өглөг	371,800.00	314,500.00
ААНОАТ-ын өр	18,700,255.38	15,373,351.81
ХХОАТ-ын өр	5,492,824.10	8,911,808.00
НДШ-ийн өглөг	7,902,400.00	8,062,100.00
Бусад өглөг	43,775,860.10	47,632,860.10
Өр төлбөрийн дүн	**76,243,139.58**	**80,294,619.91**

ТОДОТГОЛ 8 - ЭЗДИЙН ӨМЧ

а.Хувьцаа

ҮЗҮҮЛЭЛТ	Эргэлтэнд байгаа энгийн хувьцаа /ширхэг/	Давуу эрхтэй хувьцаа /мян.төг/	Өмчийн дүн /мян.төг/
Эхний үлдэгдэл	1,900,000	-	1,900,000,000.00
Эцсийн үлдэгдэл	**1,900,000**	**-**	**1,900,000,000.00**

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар компанийн эздийн өмч нь 1,900,000.0 мянган төгрөг буюу нэг бүр нь 1,000.00 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,900,000 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх бөгөөд Канад улсын "Петерсон Инвестмент Монголиа" компани 100.0 хувь эзэмшиж байна.

ТОДОТГОЛ 9 – ХҮҮГИЙН ОРЛОГО, ХҮҮГИЙН БУС ОРЛОГО, БУСАД ОРЛОГО

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31	2022/12/31
Хүүгийн орлого	**538,007,538.00**	**430,224,745.00**
Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	538,007,538.00	430,224,745.00
Банкин дахь харилцах дансны хүүгийн орлого	-	-
Хүүгийн бус орлого	**6,777,482.12**	**1,099,750.00**
Гадаад валютын ханшийн тэгштгэлийн орлого	23,612.98	67,616.24
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	6,753,869.14	1,032,133.76
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	**7,138,375.00**	**30,500,267.00**
Нийт дүн	**551,923,395.12**	**461,824,762.00**

ТОДОТГОЛ 10 – ЗАРДАЛ

а. Хүүгийн болон хүүгийн бус зардал, болзошгүй эрсдлийн зардал

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31	2022/12/31
Хүүгийн бус зардал	**328,741,508.45**	**362,220,117.30**
Арилжаа болон ханшийн тэгштгэлийн зардал	-	-
Гадаад валютын ханшийн тэгштгэлийн зардал	-	-
Боловсон хүчний холбогдолтой зардал	**211,236,780.45**	**248,694,304.89**
Ажиллагчдын цалингийн зардал	142,331,007.00	144,307,671.00
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	15,908,258.00	18,445,365.89
Томилолтын зардал	52,997,515.45	85,941,268.00
Бусад зардал	**117,504,728.00**	**113,525,812.41**
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбогдон гарсан зардал	2,356,428.78	3,466,235.00
Мэргэжлийн үйлчилгээний зардал	2,945,776.00	3,598,000.00
Түрээсийн зардал	54,700,000.00	54,100,000.00
Ашиглалтын зардал	4,876,247.00	5,675,143.00
Элэгдэл хорогдлын зардал	8,063,704.86	9,472,063.59
Харилцаа холбоо, интернетийн зардал	8,027,051.21	15,974,524.12
Сэлбэг хэрэгсэл, засвар үйлчилгээний зардал	17,197,825.30	5,298,046.00
Шатахуун, тээврийн зардал	9,126,732.12	9,102,798.00
Зохицуулалтын хураамжийн зардал	3,000,000.00	3,000,000.00
Хөдөлмөр хамгаалал, галын аюулаас хамгаалах зардал	-	245,000.00
Автоматжуулалттай холбоотой урсгал зардал	676,500.00	676,500.00
Зар сурталчилгаа, маркетингийн судалгааны зардал	200,000.00	200,000.00
Бичиг хэргийн зардал	719,024.00	974,700.00
Ариун цэврийн зардал	868,321.22	1,198,127.00
Бусад зардал	4,747,090.51	544,675.70
Болзошгүй эрсдлийн зардал	**41,783,780.00**	-
Зээлийн эрсдлийн зардал	41,783,780.00	-
Нийт дүн	**370,525,288.45**	**362,220,117.30**

б. Бусад зардал

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31	2022/12/31
Баяр ёслолын зардал	961,500.00	3,322,850.00
Бусад зардал	500,000.00	500,000.00
Нийт дүн	**1,461,500.00**	**3,822,850.00**

ТОДОТГОЛ 11 - ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

ҮЗҮҮЛЭЛТ	2021/12/31	2022/12/31
Тайлант үеийн орлогын татварын зардал	17,423,841.90	23,164,732.49
Орлогын татварын зардлын дүн	**17,423,841.90**	**23,164,732.49**

ТАЙЛАГНАЛЫН ДАРААХ ҮЙЛ ЯВЦ

Санхүүгийн тайлангийн өдөр болон аудитын тайлан бэлтгэсэн өдрийн хооронд тохиолдсон болон үйл ажиллагаанд нөлөөлөх томоохон өөрчлөлт, үйл явдал гараагүй болно.

Менежментийн захидал

“Аккурэйт финанс Аудит” ХХК нь санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал ННБОУС, СТОУС болон аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь үйлчлүүлэгч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Эл эс финанс ББСБ” ХХК-ийн удирдлага болон, санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дараалаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

АУДИТОРЫН ЗӨВЛӨМЖ

- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар журам, СТОУС-уудын нэмэлт өөрчлөлтүүд мөрдөж ажиллах,*

- *Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.1-т " ... татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татварт тооцох алдангийн хэмжээг Монголбанкнаас зарласан арилжаааны банкуудын зээлийн хүүгийн жилийн жигнэсэн дунджаас 20 хувиар илүү байхаар ..." гэж зааснаар хариуцлага хүлээх эрсдэлтэй,*

- *Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-т зааснаар урьдчилан тодорхойлсон хугацаанд дагуу сар бүр төлөх татвараа сар бүрийн 25-ны дотор, улирлын эцэст хийсэн тооцооны дагуу татвараа дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн эцэст хийсэн эцсийн тооцооны дагуу татвараа дараа оны 02 дугаар сарын 10-ны дотор төсөвт төлнө...." гэснийг дагаж мөрдөх,*

- *Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6-т зааснаар "Албан татвар төлөгч нь ... энэ хуулийн 14, 18 дугаар зүйлд тодорхойлсон орлогод ногдох албан татварыг дараа сарын 10-ны дотор холбогдох төсөвт төлж, ... " гэснийг дагаж мөрдөх,*

- *Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "...дутуу төлөгдсөн буюу хугацаандаа төлөгдөөгүй шимтгэлийг нөхөн төлүүлж, шимтгэлийн дүнгээс хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0,1 хувийн алданги ногдуулна. Энэхүү алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 30 хувиас хэтрэхгүй байх ..." гэж зааснаар хариуцлага хүлээх эрсдэлтэй,*

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, зохион байгуулалт, үйл ажиллагаа, менежмент, хууль, тогтоол, заавар, журмыг хэрэгжүүлэх талаар та бүхний хийж буй ажлыг улам сайжруулахын тулд бидний өгч буй зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана гэдэгт итгэж байна.

АУДИТОР ***Ч.БАТ-ЭРДЭНЭ***
(Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогч, БУМ)